



МОНГОЛ УЛСЫН  
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Дүрэм, журам батлах тухай

Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далай ашиглах тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийн шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор “Далбааны улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хяналтын байцаагчийн ажлын хувцас, үнэмлэх, тэмдэгний загвар, техник хэрэгсэл тэдгээрийг хэрэглэх дүрэм”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Далбааны улсын хяналтын байцаагчийн үзлэг шалгалт явуулах ажлын журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, Зөрчил гаргасан тохиолдолд хөлөг онгоцонд торгууль ногдуулах нэхэмжлэхийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалаар баталсан дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Д.Амартүвшин/-д даалгасугай.

3. Далбааны улсын хяналтын байцаагчийн дүрэмт хувцас, тэмдэг, техник хэрэгслээр хангахтай холбогдсон зардлын төсвийг байгууллагын жил бүрийн төсөвт тусган ажиллахыг нягтлан бодогч /П.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ТҮВШИНТӨР



## ДАЛБААНЫ УЛСЫН ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМТ ХУВЦАС, ҮНЭМЛЭХ, ТЭМДЭГ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Далай ашиглах тухай хууль”, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, олон улсын гэрээ, конвенцийн шаардлагыг биелүүлэх зорилгоор Далбааны улсын хяналтын байцаагчийн дүрэмт хувцас, тэмдэг хэрэглэх, Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд техникийн хяналт, үзлэг хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Далбааны улсын хяналтын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх үедээ дүрэмт хувцсыг заавал хэрэглэнэ.
- 1.3 Далбааны улсын хяналтын байцаагчийн дүрэмт хувцас, үнэмлэх, тэмдгийг салбарын инженер мэргэжилтэй эсхүл Далбааны улсын байцаагчийн холбогдох сургалтад хамрагдсан, Далайн захиргааны жинхэнэ ажилтан буюу далбааны улсын хяналтын байцаагчаар томилогдсон Монгол Улсын иргэн хэрэглэнэ.

### Хоёр. Дүрэмт хувцас, байцаагчийн тэмдэг, ажлын үнэмлэх

- 2.1. Далбааны улсын байцаагчийн дүрэмт хувцас нь дараах иж бүрдэлтэй (Дүрэмт хувцасны иж бүрдлийг энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтад харуулав) байна. Үүнд:
- 2.1.1. **малгай** – хар хөх өнгийн, саравчтай, урд талдаа Далайн захиргааны логотой, ар талдаа “Flag State Inspector” (FSI- Далбааны улсын хяналтын байцаагч) гэсэн бичвэртэй байна.
- 2.1.2. **гутал** – хөлийг механик биетийн үйлчлэл болон химийн бодис, цахилгаан, ус чийгнээс хамгаалагдсан материалаар хийгдсэн байна.
- 2.1.3. **хантааз** – улбар шар өнгийн, торон материалаар хийгдсэн, энгэрийн баруун дээд халаасан дээр “Далбааны улсын хяналтын байцаагч” гэсэн үгийн товчлол буюу “FSI”, энгэрийн зүүн дээд халаасан дээр хяналтын байцаагчийн овог, нэрийг латин үсгээр бичсэн байна. Хантаазны ар талд “MONGOLIA MARITIME ADMINISTRATION” (Монгол Улсын Далайн захиргаа) гэсэн үгийг гэрэл ойлгох хар хөх өнгийн материалаар оёсон байна. Мөн ар болон урд талд 5 см-ын өргөнтэй цагаан саарал өнгийн гэрэл ойлгогч туузыг хэвтээ болон босоо байрлалаар оёсон байна.
- 2.1.4. **хамгаалалтын малгай** (каска) – аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, урд хэсэгтээ чийдэнтэй, чихэвчтэй байна. Урд талын гол хэсэгт Далайн захиргааны лого, хойд талд “Flag State Inspector” (Далбааны улсын хяналтын байцаагч) гэсэн бичвэр байна.

2.2. Далбааны улсын хяналтын байцаагч нь хөлөг онгоцонд аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалт хийсэн тухай хяналтын хуудсанд тэмдэглэн гарын үсэг зурж, өөрийн хувийн дугаар бүхий байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна (Байцаагчийн тэмдгийн загварыг энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад үзүүлэв).

2.3. Далбааны улсын хяналтын байцаагчийн тэмдгийг зөвхөн хяналт шалгалтын ажилтай шууд холбоотой, тухайн хяналтын байцаагчийн гарын үсэг бүхий мэдэгдэл, техникийн дүгнэлт, аюулгүй ажиллагааны үзлэгийн тайлан, хяналтын хуудас, тайлан мэдээ зэрэг баримт бичгийг баталгаажуулах зорилгоор хэрэглэнэ.

2.4. Далбааны улсын хяналтын байцаагчийн эрх бүхий этгээдэд Далайн захиргааны даргын тушаалаар ажлын үнэмлэх, байцаагчийн тэмдэг олгох бөгөөд уг үнэмлэх, тэмдэг нь Монгол Улсын Далайн захиргааны өмч байна.

2.5. Ажлын үнэмлэх нь уг этгээдэд далбааны улсын хяналтыг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Далайн захиргаанаас хяналтын байцаагчийн бүрэн эрх олгосныг нотлох баримт бичиг болно (Ажлын үнэмлэхний загварыг энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад үзүүлэв).

### **Гурав. Техник хэрэгсэл, түүнийг хэрэглэх шаардлага**

3.1. Далбааны улсын хяналтын байцаагч нь хяналтын үүргээ гүйцэтгэх үедээ холбогдох дүрэм, журмын дагуу дор дурдсан техник, хэрэгсэл ашиглах ёстой бөгөөд эдгээр техник, хэрэгслээс гадна техник технологийн хувьд илүү дэвшилттэй багаж, хэрэгслийг үзлэг, шалгалтандаа ашиглаж болно. Үүнд:

3.1.1. аливаа зөрчлийг баримтжуулах фото зургийн аппарат, дүрс бичлэгийн камер;

3.1.2. гар чийдэн, чихэвч;

3.1.3. жижиг алх.

3.1.4. үзлэг шалгалтын тайлан, тэмдэглэл хөтлөхөд шаардагдах ус, чийгнээс хамгаалагдсан зөөврийн компьютер, зөөврийн хэвлэх төхөөрөмж (принтер).

3.2. Хяналтын байцаагч нь дээрх техник, хэрэгслийг зөвхөн албан хэрэгцээнд, зориулалтын дагуу ашиглах бөгөөд тэдгээр техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллана.

3.3. Хяналтын байцаагч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эзэмшиж байгаа техник, хэрэгслийг үрэгдүүлсэн буюу эвдсэн (ажиллах боломжгүй болсон) тохиолдолд байгууллагад учруулсан хохирлыг барагдуулах үүрэгтэй.

ДАЛБААНЫ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЗАГВАР



Зураг 1. Хамгаалалтын малгай (каска)



Зураг 2. Ажлын гутал



Зураг 3. Хантааз

ДАЛБААНЫ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН  
АЖЛЫН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

 <p>ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ MINISTRY OF ROAD AND TRANSPORT DEVELOPMENT OF MONGOLIA ДАЛАЙН ЗАХИРГАА MONGOLIA MARITIME ADMINISTRATION</p>	
	<p>Далбааны улсын хяналтын байцаагч Flag State Inspector</p>	
	<p>Үнэмлэхний дугаар / Identity card No. _____</p>	
	<p>Овог, Нэр / Name of holder <u>ZOLBOO Ganbatar</u></p>	
	<p>Олгосон огноо / Date of issue <u>01.01.2017</u></p>	
	<p>Дуусах огноо / Date of expire <u>01.01.2022</u></p>	
<p>Тамга Official seal</p>	<p>Эзэмшигчийн гарын үсэг Signature of holder _____</p>	

This is certified that the holder of this document is duly authorized to carry out Flag State Control inspections on board of Mongolian flagged ships in accordance with the national and international legislation.

This identify card is property of Mongolia Maritime Administration



Director of  
Mongolia Maritime Administration

ДАЛБААНЫ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН  
ТЭМДГИЙН ЗАГВАР



Хяналтын байцаагчийн нэр

Байцаагчийн хувийн дугаар

Далайн захиргааны даргын 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 45 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



## Далбааны улсын хяналтын байцаагчийн үзлэг, шалгалт явуулах журам

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Далайн тээврийн болон далайг бохирдлоос урьдчилан сэргийлэх талаарх үндэсний хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцонд Далбааны улсын хяналтын байцаагч нь үзлэг, шалгалт явуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Энэхүү журмын дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцонд Далбааны улсын үзлэг, шалгалт хийхээр Монгол Улсын Далайн захиргаанаас томилогдсон эрх бүхий этгээдийг “Далбааны улсын хяналтын байцаагч” (цаашид “хяналтын байцаагч” гэх) гэнэ.

### Хоёр. Далбааны улсын үзлэг, шалгалтын зорилго

- 2.1. Далбааны улсын хяналтын үзлэг, шалгалт дараах зорилготой байна. Үүнд:
  - 2.1.1. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцнууд техникийн аюулгүй ажиллагааг хангаж, далайн тээврийн аюулгүй байдал болон хүрээлэн буй орчныг бохирдлоос хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг баталгаажуулах;
  - 2.1.2. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцнуудад олон улсын болон үндэсний хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх;
  - 2.1.3. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцнуудын бодит нөхцөл байдал нь хөлөг дээр авч яваа гэрчилгээнүүдийн шаардлагатай нийцэж байгаа эсэхийг тодорхойлох. Энэ ажлын хүрээнд дараах зүйл багтана: Үүнд:
    - 2.1.3.1. Их бие, тоног төхөөрөмж болон багийн гишүүдийн бүрдэл;
    - 2.1.3.2. Аюулгүй ажиллагааны менежмент;
    - 2.1.3.3. Аюулгүй байдлын систем;
    - 2.1.3.4. Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай олон улсын конвенцийн шаардлагуудын хэрэгжилт.
  - 2.1.4. Хөлгийн багийн гишүүд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байдал:
    - 2.1.4.1. Осол аваарын үед тэд хамтран ажиллах;
    - 2.1.4.2. Аюулгүй ажиллагааны амин чухал ажил үүргээ биелүүлэх;
    - 2.1.4.3. Бохирдлоос сэргийлэх эсвэл түүнийг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа ажил.
  - 2.1.5. Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын гүйцэтгэсэн ажил, Далбааны улсын

нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахаар томилогдсон шинжээчдийн ажлыг хянан шалгах.

### **Гурав. Үзлэг, шалгалт явуулах**

- 3.1. Далбааны улсаас хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжлийн байцаагч үзлэг, шалгалтыг явуулна.
- 3.2. Үзлэг, шалгалт дууссаны дараа хөлгийн ахмад үзлэг, шалгалтын тайлантай заавал танилцана.
- 3.3. Үзлэг, шалгалтын тайланд дурдсан нөхцөлийн дагуу хөлгийн ахмад нь аливаа зөрчлийг арилгах шаардлагатай арга хэмжээ авна.

### **Дөрөв. Хяналтын байцаагчид тавигдах шаардлагууд**

- 4.1. Хяналтын байцаагч дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
  - 4.1.1. Далбааны улс буюу Далайн захиргаанаас томилогдсон байх;
  - 4.1.2. Хөлгийн тавцангийн 1 дүгээр зэргийн офицер/инженер офицер байх;
  - 4.1.3. Далбааны улсад хүлээн зөвшөөрөгддөг инженерийн болон шинжлэх ухааны чиглэлийн дээд боловсролын болон түүнтэй дүйцэхүйц мэргэжлийн зэрэгтэй байх;
  - 4.1.4. Далайн салбарын ажлын туршлагатай байх;
  - 4.1.5. Холбогдох сургалтын хөтөлбөрт хамрагдаж мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн түвшинтэй адил зэргийн стандартын мэдлэгтэй байх;
  - 4.1.6. Хөлөг онгоцны тавцан өөд авирах/буух, хөлгийн хөдөлгүүр ёроолын хэсэгт орох зэрэг биеийн хүч шаардсан хөдөлгөөн хийхэд эрүүл мэндийн хувьд тохирохуйц байх.

### **Тав. Хөлөг онгоцыг саатуулах**

- 5.1. Хэрэв Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц далайн тээврийн болон далайг бохирдлоос урьдчилан сэргийлэх талаарх үндэсний хууль, тогтоомжийн дагуу техникийн аюулгүй ажиллагаагаа хангаагүй эсхүл аливаа шаардлагыг зөрчсөн тохиолдолд далбааны улсын захиргаа нь уг хөлөг онгоцыг саатуулж болно.
- 5.2. Хөлөг онгоц эзэмшигч нь хөлөг онгоц саатуулагдсан тухай мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно. Шүүхэд гомдол гаргасан нь саатуулагдсан шийдвэрийг цуцлах үндэслэл болохгүй.

### **Зургаа. Үзлэг, шалгалтын бэлтгэл ажиллагаа**

- 6.1. Хяналтын байцаагч нь үзлэг шалгалт явуулах гэж буй хөлөг онгоцыг боомтод ирэхээс өмнө тухайн хөлөг онгоцны төлөөлөгчтэй урьдчилан холбоо барьж үзлэг, шалгалт явуулах гэж байгаа тухайгаа мэдэгдсэн байна.
- 6.2. Хөлөг онгоцны төлөөлөгч нь хөлгийн ахмадад Далбааны улсаас үзлэг шалгалт

явуулах гэж байгааг мэдэгдэх бөгөөд хөлгийн ахмад нь боомтод ирэхээр төлөвлөсөн хугацаа (ИТХ)-гаа төлөөлөгчид мэдэгдэх ёстой.

6.3. Хөлөг онгоцны төлөөлөгч нь хяналтын байцаагчийг хөлөг онгоцон дээр гарахад шаардагдах, боомтын холбогдох зөвшөөрлүүдийг авсан байна.

6.4. Хяналтын байцаагч нь хөлөг онгоцны төлөөлөгчтэй амаар ярилцаж тохиролцсон зүйлээ албан ёсны болгох зорилгоор заавал бичгээр баталгаажуулсан байна.

6.5. Хяналтын байцаагч нь хөлөг онгоц боомтод ирмэгц хөлөг онгоцны тавцан дээр яаралтай гарч үзлэг, шалгалтаа явуулна. Үзлэг, шалгалтыг хөлөг онгоцны багийн гишүүд бүгд бүрэн бүрэлдэхүүнээрээ онгоцон дээрээ байх үед болон хөлөг онгоцны бүх хэсэг бүрэн ажиллаж байх нөхцөлд явуулахыг эрмэлзэх ёстой.

6.6. Хяналтын байцаагч нь үзлэг, шалгалт явуулахын өмнө хөлгийн ахмадад өөрийн биеийн байцаалт, үнэмлэхээ үзүүлэх ёстой.

### **Долоо. Үзлэг шалгалт явуулах ажиллагаа**

7.1. Хяналтын байцаагч нь хөлөг онгоц бол далайчны хувьд түүний гэр орон, ажлын байр гэсэн ойлголттойгоор үзлэг, шалгалтаа явуулдаг байх ёстой.

7.2. Үндэсний хууль, тогтоомж болон олон улсын гэрээний дагуу хөлөг онгоцны үйл ажиллагаа нь аюулгүй, байгальд ээлтэй, найдвартай байх нь хамгийн чухал бөгөөд хяналтын байцаагч нь үзлэг, шалгалтын тайланд тэмдэглэгдсэн аливаа зөрчил, дутагдлыг тухай бүр эсвэл аль болох хурдан хугацаанд арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах талаар хөлгийн ахмад, ахлах офицеруудад сайтар ойлгуулахад анхаарах ёстой.

7.3. Далбааны улсын үзлэг, шалгалт нь хөлгийн ахмад, офицерууд болон багийн гишүүдэд тухайн хөлөг онгоцны аюулгүй үйл ажиллагаа, тээврийн аюулгүй байдал болон байгаль орчинд ээлтэй байдал зэргийг өндөр түвшинд хангаж ажиллахыг анхааруулах, зөвлөн туслах, тухайн үзлэг, шалгалтын үеэр тэмдэглэгдсэн зөрчил, дутагдлын талаар хөлөг онгоц эзэмшигчид, оператор, менежерүүдэд мэдэгдэх зорилго, чиг хандлагатай байна.

7.4. Үндэсний хууль тогтоомж болон олон улсын конвенцийн дагуу хөлөг онгоцны үйл ажиллагаа нь хэвийн, хөлөг онгоц зохих ёсны шаардлагад нийцсэн багийн гишүүдтэй байгааг баталгаажуулахын тулд хяналтын байцаагч нь хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, гал унтраах хэрэгслийн нөхцөл байдалд чиглэсэн шалгалт явуулна.

7.5. Хяналтын байцаагч нь Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага/ Ангиллын нийгэмлэгийн хариуцсан чиглэлийн буюу аюулгүй ажиллагаатай холбоотой тоног төхөөрөмжийн бүрэн хэмжээний үзлэг, шалгалтыг явуулах шаардлагагүй. Гэсэн хэдий ч аврах хэрэгсэл болон гал унтраах тоног төхөөрөмжид зохих ёсны дагуу үйлчилгээ хийсэн, цаашид тогтмол хийнэ гэдгийг баталгаажуулахын тулд үүнд чиглэсэн үзлэг, шалгалт явуулна.

7.6. Гал унтраах төхөөрөмжийн шахуурга, генератор, хоолой, галын хаалт, түргэн хаах хавхлаг болон бусад ижил төстэй гал унтраах, аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжүүд зэрэг онцгой байдлын үед хэрэглэгдэх төхөөрөмжүүдийг шалгах ёстой бөгөөд тэдгээрийн хүчин чадал, ажиллагаанд ямар нэгэн эргэлзээ гарвал аль болох даруйхан баталгаажуулах шаардлагатай.

7.7. Хэрэв үзлэг, шалгалтын үеэр дээрх тоног төхөөрөмж байхгүй байвал, зохих тоо хэмжээнээсээ дутуу эсхүл зохих ёсоор ажиллахгүй, техникийн гэрчилгээтэйгээ нийцэхгүй байх зэрэг зөрчил илэрсэн тохиолдолд хяналтын байцаагч нь энэ тухай хөлгийн ахмадад мэдэгдэнэ. Хөлгийн ахмад нь тухайн зөрчлийг залруулах арга хэмжээ авахыг Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага/Ангиллын нийгэмлэгэд мэдэгдэх үүрэгтэй.

7.8. Хяналтын байцаагч бүр аюулгүй ажиллагаа болон гал унтраах төхөөрөмжийн



нөхцөл байдлын талаар тэмдэглэл хийх ёстой. Боломжтой тохиолдолд хяналтын байцаагч нь галын эсхүл ослын үед хөлгийг орхих үзүүлэх сургуулилалт хийхийг хөлгийн ахмадаас шаардаж болно. Гэвч эдгээр сургуулилалт нь боомтын үйл ажиллагаанд (ачаа ачиж, буулгах ажиллагаа гэх мэт) саад болох ёсгүй бөгөөд ийм сургуулилалтыг боомтоос гаргасан зааварчилгааны дагуу явуулна. Хэрэв сургуулилалт хийгдсэн бол тухайн багийн гишүүдийн ур чадвар, гүйцэтгэл өөрөөр хэлбэл онцгой байдлын үед аврах арга хэмжээний үед жагсаалтын дагуу өөрсдийн үүргээ биелүүлэх мэдлэг, чадвартай эсэх талаар тайланд тэмдэглэнэ.

7.9. Хяналтын байцаагч нь хөлөг онгоцны үзлэг шалгалтыг ажлын 1-2 өдөрт (ойролцоогоор 8-16 цаг) багтаан явуулж дуусгана.

### **Найм. Далбааны улсын үзлэг, шалгалтын тайлан**

8.1. Үзлэг, шалгалтын тайланг аль болох дэлгэрэнгүй бичсэн байх нь чухал ач холбогдолтой. Хэрэв тэмдэглэл хийгдээгүй бол тэмдэглэгээг хийгээгүй шалтгаанаа тайлбарласан байна.

8.2. Хяналтын байцаагчийн илрүүлсэн аливаа зөрчлийг тайланд заавал тэмдэглэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хавсаргаж болно. Тэдгээр зөрчлийн талаар хөлгийн ахмад болон ахлах офицеруудад заавал мэдэгдэх ёстой. Хэрэв хөлөг онгоцны эзэмшигч эсхүл менежерүүдийн төлөөлөл нь үзлэг, шалгалтын үеэр байлцсан бол тэдэнд мөн адил мэдэгдэнэ.

8.3. Хяналтын байцаагчийн илрүүлсэн зөрчил нь тухайн хөлөг онгоц болон түүн дээрх далайчдын аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулах эсхүл зөрчлийг арилгахгүйгээр далайд үргэлжлүүлэн аялах боломжгүй гэж үзсэн, мөн хөлгийн ахмад/эзэмшигчид тухайн зөрчлийг залруулах талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол энэ тухай Далайн захиргаанд нэн даруй мэдэгдэнэ. Далайн захиргаа нь зөрчлийг арилгуулах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

8.4. Хөлгийн ахмад нь шалгалтын тайлантай танилцаж, хүлээн зөвшөөрсөнөө баталгаажуулан гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурсан тайлангийн нэг хувийг хөлөг онгоцон дээрээ авч үлдэнэ. Хэрэв хөлөг онгоц эзэмшигч эсхүл менежерүүдийн төлөөлөл тухайн үзлэг шалгалтын үеэр байлцсан бол гарын үсгээ зурах бөгөөд тайлангийн хуулбарыг авах хүсэлт гаргаж болно.

8.5. Хяналтын байцаагч нь үзлэг, шалгалтын тайлангийн хуулбарыг гуравдагч талд тухайлбал, хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага/ангилалын нийгэмлэг, боомт улсын хяналтын болон даатгалын байгууллага, бусад боомтын албан хаагчид, хуульчид зэрэг этгээдүүдэд Далайн захиргааны зөвшөөрөлгүйгээр дамжуулан өгч болохгүй. Хэрэв гуравдагч этгээд нь үзлэг, шалгалтын тайлангийн хуулбарыг авахыг хүсвэл Далайн захиргаанд албан ёсоор хандаж болно.

### **Ес. Фото зургаар баримтжуулах**

9.1. Хяналтын байцаагч нь хөлөг онгоцны дараах хэсгийн фото зургийг авахыг эрмэлзэх бөгөөд зургуудыг тайланд хавсаргана. Үүнд:

9.1.1. Хөлөг онгоцны нэрийг харуулсан хөлгийн хошуу хэсэг;

9.1.2. Хөлөг онгоцны нэр болон холбогдох тэмдэглэгээг харуулсан хөлгийн сүүл хэсэг;

9.1.3. ОУДБ-ын дугаар, албан ёсны дугаарын тэмдэглэгээ;

9.1.4. Хөлөг онгоц бүхэлдээ харагдах байдлын, зогсож байх үеийн эсхүл завинаас

- 11.3.4. Тасралтгүй ажиллагааны товч тэмдэглэл (Аюулгүйн менежментийн олон улсын кодыг хэрэгжүүлдэг хөлөг онгоцнуудад хэрэглэгдэнэ);
- 11.3.5. Далайчдын мэргэжлийг баталгаажуулах гэрчилгээ;
- 11.3.6. Бусад гэрчилгээнүүд (Шатахууны конвенцийн гэрчилгээ, Иргэний хариуцлагын тухай конвенцийн гэрчилгээ, Далайн хөдөлмөрийн тухай конвенцийн гэрчилгээ гэх мэт).
- 11.4. Хэрэв эдгээр гэрчилгээнүүд нь хөлөг онгоцон дээр байхгүй нь тогтоогдвол хяналтын байцаагч нь холбогдох арга хэмжээг авахуулах талаар Далайн захиргаанд нэн даруй мэдэгдэнэ.
- 11.5. Хяналтын байцаагч нь энэ журмын 11.3-д заасан гэрчилгээнүүдийн хүчинтэй хугацаа болон тухайн гэрчилгээ зохих журмын дагуу олгогдсон эсэхийг нягталж болно. Хэрэв гэрчилгээнүүдийн хүчинтэй хугацаа нь дууссан, гэрчилгээ олголт нь зохих журмын дагуу олгогдсон эсэх нь эргэлзээтэй гэж үзвэл хяналтын байцаагч нь уг асуудлыг нягтлуулахаар Далайн захиргаанд нэн даруй мэдэгдэнэ.
- 11.6. Гэрчилгээнүүдийн олгосон болон дуусах хугацаа нь хяналтын байцаагчийн үзлэг, шалгалтын тайланд тэмдэглэгдэнэ.
- 11.7. Хөлгийн ахмад болон офицерууд нь өөрсдийн эрхэлж байгаа албан тушаалын зэрэг, дэвийн дагуу зохих ёсны ур чадамжийн гэрчилгээтэй байх ёстой бөгөөд Далайн захиргаанаас уг гэрчилгээг хянаж баталгаажуулсан байна. Баталгаажуулсан гэрчилгээ нь түр гэрчилгээ буюу 3 хүртэл сарын хугацаатай, байнгын гэрчилгээ буюу 3 хүртэл жилийн хугацаатай (өөрөөр хэлбэл ур чадамжийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаатай ижил хугацаанд баталгаажуулсан гэрчилгээ нь хүчинтэй байна) байна.
- 11.8. Далайн захиргаанаас олгосон гэрчилгээ нь зохих ёсоор олгогдсон эсэхийг хяналтын байцаагч нягтлан шалгах бөгөөд хэрэв эргэлзээтэй гэж үзвэл Далайн захиргаанд даруй мэдэгдэж асуудлыг тодруулах үүрэгтэй. Мөн Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага/Ангиллын нийгэмлэгээс олгосон техникийн гэрчилгээг нэг бүрчлэн шалгана. Хэрэв тусгай нөхцөлтэй буюу “түр хугацааны” эсвэл “тусгай нөхцөлтэй” гэрчилгээ олгогдсон байвал энэ тухай тайландаа тэмдэглэнэ.
- 11.9. Хяналтын байцаагч нь тухайн үзлэг, шалгалт явуулж буй хөлөг онгоцны багийн гишүүдийн жагсаалтыг хөлгийн ахмадаас авч тайландаа хавсаргана.
- 11.10. Хэрэв үзлэг, шалгалтын үеэр багийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орвол энэ талаар хяналтын байцаагч үзлэгийн тэмдэглэл хөтөлж, багийн өөрчлөгдөж байгаа бүх гишүүдийн ур чадварын гэрчилгээг нэг бүрчлэн шалгаж тайландаа тэмдэглэнэ.

### **Арван хоёр. Багийн гишүүдийн аюулгүй ажиллагаа**

- 12.1. Багийн гишүүдийн бүрдүүлэлт нь 24 метрээс дээш урттай хөлөг онгоцон дээр заавал авч явах ёстой багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээтэй нийцэж байх ёстой.
- 12.2. Хяналтын байцаагч нь үзлэг, шалгалтын явцад Багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээний дагуу шаардагдах офицерүүд болон багийн гишүүдийн тооны хязгаарын хамгийн бага байх хэмжээг үндэслэсэн багийн гишүүдийн жагсаалтыг хөлөг дээрх багийн гишүүдийн бодит тоотой тулгах замаар шалгах ёстой. Хэрэв багийн гишүүдийн тоо бүрдээгүй бол хяналтын байцаагч нь хөлөг онгоцыг аялалд гарахаасаа өмнө нэн яаралтай багаа бүрдүүлэхийг хөлгийн ахмадаас шаардах үүрэгтэй. Хэрэв хөлгийн ахмад уг шаардлагыг эс биелүүлбэл энэ талаар Далайн захиргаанд нэн даруй мэдэгдэнэ.
- 12.3. Тухайн ажлын байранд ажиллаж байгаа далайчинд шаардагдах албан тушаалын зэрэг, дэвийн гэрчилгээг уг далайчин эзэмшиж байгаа эсэхэд шалгалт хийнэ. Хэрэв ажлын байранд ажиллаж буй далайчин нь шаардлагатай зэрэг, дэвийн гэрчилгээ байхгүй эсвэл

авсан фото зураг;

9.1.5. Хөлгийн хошуу болон сүүл хэсгийн тавцан (Удирдлага, жолоодлогын өрөө болон бусад өргөгдсөн хэсгүүдээс авсан фото зураг);

9.1.6. Яндан;

9.1.7. Удирдлага, жолоодлогын өрөө;

9.1.8. Гал тогооны өрөө;

9.1.9. Багийн гишүүдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөө;

9.1.10. Гол хөдөлгүүр (Өргөгдсөн байрлалаас авсан фото зураг);

9.1.11. Хөдөлгүүр, түүний эд ангиуд, хяналтын өрөө;

9.1.12. Аливаа ноцтой зөрчил дутагдлуудыг харуулсан фото зураг гэх мэт.

### **Арав. Боомт улсын хяналт**

10.1. Боомт улсын хяналтаар саатуулагдсан эсхүл боомт улсын шалгалт нь тухайн далбааны улсын шалгалттай нэгэн зэрэг явагдаж зөрчил илрүүлсэн бол хяналтын байцаагч нь боомт улсын шалгалтаар илрүүлсэн бүх зөрчлийг дахин шалгах бөгөөд тухайн зөрчил бүрт тэмдэглэл хөтлөн тайланд тусгана. Өөрөөр хэлбэл тухайн зөрчлийг залруулсан эсэх, цаашид ямар засвар үйлчилгээ шаардлагатайг тайланд тодорхой дурдана.

### **Арван нэг. Хөлөг онгоцны болон далайчдын гэрчилгээжүүлэлт**

11.1. Хяналтын байцаагч нь хөлөг онгоц болон далайчдад олгосон бүх гэрчилгээнүүдийг нэг бүрчлэн нягтлан шалгана. Хэрэв аль нэг гэрчилгээний хугацаа дууссан нь тогтоогдвол энэ тухай тайланд зайлшгүй дурдах ёстой бөгөөд цаашид авах шаардлагатай арга хэмжээг мөн тусгасан байна.

11.2. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлсэн хөлөг онгоц нь Олон улсын далайн байгууллагын 2017 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн FAL.2/Circ.131, MEPC.1/Circ.873, MSC.1/Circ.1586, LEG.2/Circ.3 дугаар тогтоолуудад дурдсан гэрчилгээнүүдийг хөлөг онгоцон дээрээ заавал авч явах үүрэгтэй.

11.3. Мөн түүнчлэн хөлөг онгоц нь Монголын хөлөг онгоцны бүртгэлийн байгууллагаас олгосон дараах гэрчилгээнүүдийг хөлгийн тавцан дээр авч явах ёстой. Үүнд:

11.3.1. Бүртгэлийн гэрчилгээ:

- 6 хүртэл сарын хугацаатай түр бүртгэлийн гэрчилгээ
- 12 хүртэл сарын хугацаатай байнгын бүртгэлийн гэрчилгээ;

11.3.2. Багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээ (24 метрээс илүү урттай хөлөг онгоцонд зайлшгүй байна):

- 6 хүртэл сарын хугацаатай түр гэрчилгээ
- 12 хүртэл сарын хугацаатай байнгын гэрчилгээ;

11.3.3. Хөлөг онгоцны радио холбооны гэрчилгээ:

- 6 хүртэл сарын хугацаатай түр гэрчилгээ
- 12 хүртэл сарын хугацаатай байнгын гэрчилгээ;

далбааны улс уг зэрэг, дэвээс чөлөөлсөн гэрчилгээ олгоогүй тохиолдолд хөлөг онгоц аялалд гарахаас өмнө нэн даруй багийн гишүүнийг өөрчлөхийг шаардах үүрэгтэй.

12.4. Далайн тээврийн дэлхий нийтийн аюулгүй байдлын систем (ДТДНАС)-ээр тоноглогдсон хөлөг онгоц нь ДТДНАС-ийн радио оператор-1 эсхүл ДТДНАС-ийн ерөнхий операторын гэрчилгээтэй тавцангийн офицер-2 (нэг нь хөлгийн ахмад байж болно) байх ёстой.

12.5. Хэрэв Багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээн дээр хөдөлгүүрийн өрөөг багийн гишүүдгүй, ээлжийн ажиллагаатай гэж тэмдэглэсэн боловч үүнийг Ангиллын нийгэмлэгээс түдгэлзүүлж, багийн гишүүдтэй болгосон бол хөлгийн ахмад нь хөдөлгүүрийн өрөөнд багийн нэмэлт гишүүдийг яаралтай бүрдүүлэх ёстой.

12.6. Хөлөг онгоцны аюулгүй байдлын олон улсын код мөрдөгдөх бүх хөлөг онгоцнуудад Багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээн дээр тэмдэглээгүй боловч хөлөг онгоцны аюулгүй байдлын офицер 1-ийг заавал томилох ёстой.

### **Арван гурав. Аюулгүй ажиллагааны менежментийн олон улсын код**

13.1. Аюулгүй ажиллагааны менежментийн олон улсын код (ААМК)-ын зорилго нь далай дахь хөлөг онгоцны техникийн аюулгүй ажиллагааг хангах, осол гэмтэлд өртөх эсхүл амь насаа алдахаас сэргийлэх, далайн хүрээлэн буй орчин ба өмч хөрөнгөд хохирол учруулахаас зайлсхийх зэрэг үйл ажиллагааг хангахад оршино.

13.2. Хяналтын байцаагч нь үзлэг, шалгалт явуулахдаа хөлөг онгоцны Аюулгүй ажиллагааны менежментийн системийн хэрэгжилтийг нэн тэргүүнд шалгах ёстой.

13.3. Далбааны улсын үзлэг, шалгалт нь хөлөг онгоцны эзэмшигчээс тогтоож өгсөн Аюулгүй ажиллагааны менежментийн системийн нэмэлт үзлэг, шалгалт болж өгдөг ба түүнийг хөлгийн тавцан дээр хөлгийн ахмад хэрэгжүүлдэг.

13.4. Хөлгийн ахмад ААМК-ыг бүрэн хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлсэн гэх боловч түүнийг нотлох баримтгүй, хөлөг онгоц дээр ААМК-ын техникийн гэрчилгээнүүд байхгүй бол хяналтын байцаагч нь энэ талаар тайландаа тэмдэглэн Далайн захиргаанд мэдээлнэ.

13.5. Аюулгүй ажиллагааны менежментийн систем гэдэг нь хөлөг онгоцон дээр хөлгийн ахмад болон багийн гишүүдэд, хөлөг онгоцны эзэмшигчдэд байх аюулгүй ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө юм. Энэ төлөвлөгөө нь багийн гишүүдэд ойлгогдох хэл дээр байна.

13.6. Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага (ХЗБ)-аас олгосон Даган мөрдөх бичиг баримтын хуулбар нь Аюулгүй ажиллагааны менежментийн гэрчилгээтэй хамт хөлгийн тавцан дээр, мөн хөлөг онгоцны эзэмшигчид хадгалагдах ёстой. ХЗБ-аас олгосон Даган мөрдөх бичиг баримтанд тухайн хөлөг онгоцны төрөл, үйл ажиллагааг тусгасан байна. Даган мөрдөх бичиг баримт дээрх хөлөг онгоцны төрөл нь Аюулгүй ажиллагааны менежментийн гэрчилгээн дээрх хөлөг онгоцны төрөлтэй тохирч байх ёстой.

13.7. Хөлөг онгоцны эзэмшигч нь Аюулгүй ажиллагааны менежментийн төлөвлөгөөг дараах нөхцөлүүдийг тусган боловсруулсан байна. Үүнд:

13.7.1. Хөлгийн тавцан дээрх аюулгүй ажиллагааны дадлага туршлага ба ажлын байрны аюулгүй орчин;

13.7.2. Хорлон сүйтгэх ажиллагаа, хүн барьцаалах, хулгай, дээрэм зэрэг урьдчилан тооцсон бүх эрсдлийн эсрэг аюулгүй байдлыг хариуцсан ажилтнууд;

13.7.3. Аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбоотой гэнэтийн ослын үед яаралтай авах арга хэмжээний бэлтгэл хийх зэргээр хөлгийн тавцан дээрх болон эрэг дээрх Аюулгүй ажиллагааны менежментийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх.

13.8. Хөлгийн ахмадын өөрийн үүрэг хариуцлага ба эрх мэдлийн хүрээнд дараах үүрэг

хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

13.8.1. аюулгүй ажиллагаа ба хүрээлэн буй орчны бодлогыг хэрэгжүүлэх, үүнд багийн гишүүдийн оролцоог идэвхжүүлэх;

13.8.2. Ойлгомжтой, хялбар хэлбэрээр зөв, тохирохуйц даалгавар, зааварчилгаа өгөх;

13.8.3. Аюулгүй ажиллагааны менежментийн системийг хянан шалгах ба илэрсэн зөрчил, дутагдлыг удирдлагад танилцуулах.

13.9. Хяналтын байцаагч дараах асуудлыг шалгана. Үүнд:

13.9.1. Хөлгийн ахмад нь Аюулгүй ажиллагааны менежментийн системийн үүрэг, хариуцлагаа ухамсарлан ойлгож түүнийг хэрэгжүүлж байгаа эсэх;

13.9.2. Аюулгүй ажиллагааны менежментийн системийн гарын авлага нь хөлгийн тавцан дээр байгаа багийн гишүүдэд танилцахад нээлттэй байх;

13.9.3. Ахмад нь Аюулгүй ажиллагааны менежментийн системийн хүрээнд эн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлж чадаж байгаа эсэх;

13.9.4. Гэнэтийн ослын үед холбоо тогтоох, мэдэгдэх талаарх журам байгаа эсэх;

13.9.5. Аюулгүй ажиллагааны менежментийн системийн шаардлагын дагуу хөлөг онгоцны эзэмшигчээс дотоод хяналт хийгдсэн эсэх;

13.9.6. Осол аваар, зөрчил дутагдал, аюул ослын тохиолдлын талаар компани/ангиллын нийгэмлэгэд мэдээлсэн тухай тайлан байгаа эсэх;

13.9.7. Гол суурь машин ба тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг шалгасан талаар хөтөлсөн тэмдэглэл байгаа эсэх, одоогийн үйл ажиллагааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн эсэх;

13.9.8. Амь нас хамгаалах ба гал унтраах хэрэгслийн засвар үйлчилгээг шалгасан талаар хөтөлсөн тэмдэглэл байгаа эсэх, одоогийн үйл ажиллагааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн эсэх;

13.9.9. Хөлгийн ахмад болон ахлах офицерууд эрэг дээр хөлөг онгоцны үйл ажиллагааг хариуцахаар томилогдсон төлөөлөгч, этгээдийг мэдэж байгаа эсэх;

13.9.10. Аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтын үеэр Аюулгүй ажиллагааны менежментийн системийн холбогдох зүйл заалтыг ойлгож байгаа болон хөлгийн гишүүд энэ талаар сургалтад хамрагдсан эсэх;

13.9.11. Хөлгийн ахмад нь хөлгийг боомтод очих, боомтоос гарах үеийн аюулгүй ажиллагааны хяналтын хуудас ашигладаг эсэх, ачаа ачих, буулгах ажиллагаа эхлэхээс өмнө түүний үйл ажиллагааны журмыг шалгасан эсэх.

### **Арван дөрөв. Багийн гишүүдийн амрах байр**

14.1. Багийн гишүүдийн амрах байрны аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжийг шалгах явцдаа хяналтын байцаагч нь орон байрны нөхцөл байдалд давхар үзлэг, шалгалт явуулж болно. Үзлэг шалгалтаар дараах зүйлд голчлон анхаарна. Үүнд:

14.1.1. Дотоод засал чимэглэл – ерөнхий нөхцөл байдал, цэвэрлэгээ; Дулаалга, тусгаарлалт – хөлгийн хажуу хана ба тавцан талын дээвэр;

14.1.2. Агааржуулалт – ажиллагаатай эсэх, ямар нэгэн гэмтэл, согог байгаа эсэх;

14.1.3. Гэрэлтүүлэг – ажиллагаатай эсэх, тоноглол болон хамгаалалт нь бүрэн, эвдрэл, гэмтэлтэй эсэх;

14.1.4. Аваарын гарц – саадгүй чөлөөтэй орж, гарах боломжтой эсэх, гарцын тэмдэглэгээ нь тодорхой, ойлгомжтой байдлаар тэмдэглэгдсэн эсэх;

14.1.5. Эрүүл ахуй – бие засах өрөө, угаалгын өрөөнүүд шаардлагатай усны нөөцөөр хангагдсан, цэвэрхэн эсэх; ариун цэврийн, бохирын хоолойнууд бүрэн бүтэн, цоорч гоожсон эсэх; хорхой шавьж, мэрэгч амьтны устгалын тэмдэг, тэмдэглэгээ байгаа эсэх;

14.1.6. Ундны ус – усны хангамжийн зохицуулалт;


14.1.7. Гал тогоо – цэвэрлэгээ, ерөнхий нөхцөл байдал, хиншүү сорогч/ тос шүүгчийн цэвэрлэгээнд онцгой анхаарна. Мөн гал унтраах багаж хэрэгсэл байгаа эсэх;

14.1.8. Багийн гишүүдийн амрах хэсэгт эд зүйл хадгалж, хураасан эсэх;

14.1.9. Сургалт, засвар үйлчилгээний болон багийн гишүүдэд танилцуулах гарын авлага зэргийг ашигладаг эсэх.

---oOo---

Далайн захиргааны даргын 2018 оны 06 дугаар сарын 19 ны өдрийн 10 тоот тушаалын гуравдугаар хавсралт



ЗӨРЧИЛ ГАРГАСАН ХӨЛӨГ ОНГОЦОНД НОГДУУЛАХ ТОРГУУЛИЙН  
НЭХЭМЖЛЭХИЙН ЗАГВАР



**MONGOLIA  
MARITIME  
ADMINISTRATION**

Mongolia Maritime Administration  
#612 Governmental Building-XI Chingelbei district,  
Sambuugin street-11, Ulaanbaatar, Mongolia  
Tel: (+976-51) 261485, (+976-51) 261490  
Fax: (+976-11) 310642  
Email: [info@monmarad.gov.mn](mailto:info@monmarad.gov.mn)  
Website: [www.monmarad.gov.mn](http://www.monmarad.gov.mn)  
[www.mnaonline.org](http://www.mnaonline.org)

Attn to : .....

Tax Invoice No:	MMA 0001
Date	17/3/2017

Description	Amount
-------------	--------

US\$

Ship Name : JI XIANG  
Off No: 33721384  
GRT: 1986  
NRT : 1046  
Ship type: Oil Tanker

Detention Penalty Fee \$3,500.00  
Inspection Fee \$1,500.00

MONGOLIA MARITIME ADMINISTRATION	Total before GST	\$5,000.00
	Add : GST	
	Total after GST	\$5,000.00

PLEASE REMIT BY TT (FREE OF ALL CHARGES) TO FOLLOWING A/C  
State Bank of Mongolia  
Account No.: (USD) 10500028307  
Swift Address: OTBMMNU6, State bank of Mongolia, Ulaanbaatar, Mongolia  
Intermediary Bank: DBS BANK LTD.  
Swift Code: DBS0000000  
Routing NMB: 018982

**MONGOLIA MARITIME ADMINISTRATION**  
**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА**

“Далбааны улсын хяналтын  
байцаагчийн үзлэг, шалгалт явуулах  
журам”-ын Хавсралт

**REPORT OF SAFETY INSPECTION/АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮЗЛЭГ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

1		INSPECTION PORT/ ҮЗЛЭГ ХИЙСЭН БООМТ		DATE INSPECTED/ ҮЗЛЭГ ХИЙСЭН ОГНОО	
		LAST INSPECTION/ СҮҮЛД ХИЙГДСЭН ҮЗЛЭГ		LAST SAFETY INSPECTION/ СҮҮЛД ХИЙГДСЭН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮЗЛЭГ	
		<input type="checkbox"/> INITIAL/АНХНЫ		<input type="checkbox"/> ANNUAL/ЖИЛ БҮРИЙН	
		<input type="checkbox"/> SPECIAL/ТУСГАЙ (SDV/НЭГ УДААГИЙН АЯЛАЛЫН)		<input type="checkbox"/> OCCASIONAL/ГЭНЭТИЙН	
2		NAME OF VESSEL/ ХӨЛӨГ ОНГОЦНЫ НЭР		IMO NO./ ОУДЕ-ЫН ДУГААР	
		GROSS TONNAGE/ БОХИР ДААЦ		Official No.+ Call Sign/ БҮРТГЭЛИЙН ДУГААР + ДУУДЛАГЫН ДУГААР	
		NET TONNAGE/ ЦЭВЭР ДААЦ		CLASS + NOTATION/ АНГИЛАЛ + ТЭМДЭГЛЭГЭЭ	
				TYPE/ ТӨРӨЛ	
				DATE KEEL WAS LAID/ ХИТЭГ ТАВЬСАН ОГНОО	
				KW /КВ	
NAME AND ADDRESS OF COMPANY (ISM-Code 1.1.2 and 3.1 see copy of DoC)/ КОМПАНИЙН НЭР, ХАЯГ (Олон улсын аюулгүй ажиллагааны менежментийн код 1.1.2 ба Даган мөрдөх бичиг баримт 3.1.)					
TEL. :					
FAX: E-MAIL:					
3 SHIP DOCUMENTS/хөлөг онгоцны бичиг баримт/STATUTORY CERTIFICATES/техникийн гэрчилгээ					
NAME OF CERTIFICATE/ Гэрчилгээний нэр ( acc. SOLAS Annex 2 )		Issue / Endorsement DATE Олгосон/ Баталгаажуул- сан огноо	EXPIRY DATE / or last entry дуусах хугацаа	NAME OF CERTIFICATE/ Гэрчилгээний нэр ( acc. SOLAS Annex 2 )	
				Issue / Endorsement DATE Олгосон/ Баталгаажуул- сан огноо	EXPIRY DATE / or last entry дуусан хугацаа
1	Certificate of Registry/ Бүртгэлийн гэрчилгээ		19	Safety Management Certificate (SMC) (intermediate endorsement)/ Аюулгүй ажиллагааны менежментийн гэрчилгээ (дунд хугацааны баталгаажуулалт)	
2	Ship Station Licence/ Радио холбооны гэрчилгээ		20	International Ship Security Certificate (ISSC) (intermediate endorsement)/Хөлөг онгоцны аюулгүй байдлын гэрчилгээ (дунд хугацааны баталгаажуулалт)	
3	Minimum Safe Manning Certificate/ Багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээ		21	Maritime Labour Convention Certificate (MLC 2006) (intermediate endorsement)/Далайн хөдөлмөрийн тухай конвенцийн гэрчилгээ (дунд хугацааны баталгаажуулалт)	
4	Continuous Synopsis Record/ Тасралтгүй ажиллагааны товч тэмдэглэл		22	Document of compliance with special requirements for ships carrying dangerous goods (IMDG)/Аюултай ачаа тээвэрлэгч хөлөг онгоцны тусгай шаардлага бүхий даган мөрдөх бичиг баримт	
5	Bunker Convention Certificate/		23	Certificate of Fitness for the Carriage of Dangerous Chemical	



	Шатахууны конвенцийн гэрчилгээ				in Bulk (IBC-Code)/ Аюултай химийн бодис задгайгаар тээвэрлэх чадавхийн гэрчилгээ		
6	Civil Liability Convention (CLC) for Tankers/Иргэний хариуцлагын тухай конвенцийн гэрчилгээ			24	Certificate of Fitness for the Carriage of liquefied Gases in Bulk ( IGC Code)/Шингэрүүлсэн хийг задгайгаар тээвэрлэх чадавхийн гэрчилгээ		
7	International Tonnage Certificate/ Бартаажийн хэмжилтийн гэрчилгээ			25	Int. Maritime Solid Bulk Cargoes Code (IMSBC)/Хатуу биет ачааг задгайгаар тээвэрлэх тухай код		
8	International Load Line Certificate Даацын тэмдэглэгээний гэрчилгээ			26	Stability Information (Solas II-1 Reg 22)/Тогтвортой байдлын мэдээлэл		
9	Cargo Ship Safety Construction Certificate/Ачааны онгоцны аюулгүй хийцийн гэрчилгээ			27	Damage Control Booklet (Solas II-1 Reg 23-1 ships built on or after 01.02.1992)/Эвдрэл хяналтын дэвтэр (1992 оны 2 сарын 1-нээс хойш үйлдвэрлэгдсэн хөлөг онгоцнууд хамарна)		
10	Cargo Ship Safety Equipment Certificate/Ачааны онгоцны аюулгүйн тоног төхөөрөмжийн гэрчилгээ			28	Cargo Securing Manual/ Ачаа хамгаалах гарын авлага зааварчилгаа		
11	Cargo Ship Safety Radio Certificate/ Ачааны онгоцны аюулгүй радио холбооны гэрчилгээ			29	SOPEP / SMPEP Газрын тосны бохирдлын үед хөлөг онгоцны хэрэгжүүлэх яаралтай төлөвлөгөө/Газрын тосны бохирдлын үед хөлөг онгоцны тавцан дээр хэрэгжүүлэх яаралтай төлөвлөгөө		
12	Int. Oil Pollution Prevention Cert. (IOPP) / Газрын тосны бохирдлоос сэргийлэх тухай гэрчилгээ			30	Ship Security Plan / SSP& SSA (ISPS Code) / Хөлөг онгоцны аюулгүй байдлын төлөвлөгөө		
13	IOPP Supplement/ Газрын тосны бохирдлоос сэргийлэх тухай гэрчилгээний нэмэлт			31	Oil Record Book (Part I & Part II) / Тосны тэмдэглэлийн дэвтэр		
14	Cert. (IAPP) + IAPP Supp./Агаарын бохирдлоос сэргийлэх тухай гэрчилгээ + нэмэлт			32	Garbage Management Plan and Record Book/ Хогны менежментийн төлөвлөгөө ба тэмдэглэлийн дэвтэр		
15	Int. Ship Energy Efficiency Certificate/ Хөлөг онгоцны эрчим хүчний үр ашгийн гэрчилгээ			33	Emergency Towing Booklet/ Яаралтай үед онгоц чирэх тухай тэмдэглэлийн дэвтэр		
16	Int. Sewage Pollution Prevention Cert./ Бохир усны бохирдлоос			34	Ship Energy Efficiency Management Plan/ Хөлөг онгоцны эрчим хүчний үр ашгийн менежментийн төлөвлөгөө		

	сэргийлэх тухай гэрчилгээ						
17	Anti-Fouling System Certificate/Хөлөг онгоцны гадаргууг хамгаалах системийн тухай гэрчилгээ			35	Ship to Ship Transfer Manual/ Нэг хөлөг онгоцноос нөгөө онгоцонд шилжүүлэх тухай гарын авлага зааварчилгаа		
18	Copy of Document of Compliance (DOC) (annual endorsement)/ Даган мөрдөх бичиг баримтын хуулбар (жил бүрийн баталгаажуулалт)			36			

**4 PUBLICATIONS according to "List of Publications" (tick box if on board)/шаардлагатай ном товхимолын жагсаалт**

Name of Publication/Ном товхимолын нэр	Y / T I Y M	N/үгүй	Edition/ Хэвлэгдсэн онгоо	Amendments/ Date Нэмэлтүүд /огноо
1. MARPOL/Хөлөг онгоцноос үүдэлтэй бохирдлоос сэргийлэх тухай конвенци	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
2. SOLAS/Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенци	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
3. LSA Code /Амь нас авран хамгаалах хэрэгслийн код	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
4. ISM Code/Аюулгүй ажиллагааны менежментийн код	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
5. ISPS Code/ Хөлөг онгоцны болон боомтын аюулгүй байдлын код	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
6. STCW - Convention/Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай конвенци	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
